

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС ДАХЬ ХУУЛЬЧ МЭРГЭЖЛИЙН БҮТЭЦ БОЛОН ХУУЛЬ ЗҮЙН БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦОО

Базаррагчаагийн Даваажав

Хууль сахиулахын их сургуулийн Иргэний эрх
зүйн тэнхмийн багш, цагдаагийн ахлах дэслэгч

Англо-Саксоны эрх зүйн бүлийн уламжлал ёсоор АНУ-ын нийгмийн амьдралд эрх зүйн зохицуулалтын үүрэг өндөр ач холбогдол бүхий байдаг. Америк “легализм” нь хууль зүй, өмгөөллийн үйл ажиллагааг бусад мэргэжлийн бүлгүүдтэй харьцуулахад харьцангуй өвөрмөц, онцгой байр суурьтай болгон хөгжүүлж ирсэн бөгөөд хуульчид нь улс орныхоо эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёл, улс төрийн механизмд хамгийн чухал үүргийг гүйцэтгэсээр ирсэн. Ингээд АНУ дахь хуульч мэргэжлийн бүтэц ба хууль зүйн боловсролын талаар судалсан зүйлээсээ хэсэгчлэн та бүхэнд толилуулж байна.

Хуульч мэргэжлийн бүтэц: АНУ-д ойролцоогоор 1 сая 200 мянгаар тоологдох хуульчид байдгийн дийлэнх олонх нь өмгөөллийн эрхтэй буюу хуульчийн практик үйл ажиллагааны аливаа хэлбэрт зайлшгүй нөхцөл болдог өмгөөлөлийн патенттай мэргэжлийн өмгөөлөгчид байдаг. Зөвхөн эрдэм шинжилгээ, сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаанд л өмгөөлөгчийн патент заавал шаардагддаггүй байдаг¹. Гэвч олон судлаач, эрдэмтэн хэзээ нэг цагт практик ажилд шилжих тохиолдолд шаардлагатай хэмээн үзэж хуульч мэргэжлийнхээ карьерыг эхлэх үеэрээ шалгалтанд орж өмгөөллийн эрх авахыг илүүд үздэг².

АНУ дахь хуульчийн мэргэжлийг:

- Эрх зүйтэй шууд холбоотой ажил эрхэлдэг практик хуульчид
- Хуульчийн диплом бүхий боловч эрх зүйтэй шууд холбоогүй ажил үүрэг гүйцэтгэдэг этгээдүүд
- Эрдэм шинжилгээ, сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг хуульчид гэсэн гурван ангилалд хувааж болно.

Эхний ангилалд мэргэжлийн хэд хэдэн бүлэг хамаарна. Юун түрүүнд хувиараа үйл ажиллагаа явуулдаг өмгөөлөгчид мэргэжлийн хамгийн том бүлгийг үүсгэх бөгөөд АНУ-д 700 мянгаар тоологдоно. Орон тоогоор ажиллаж, бизнесийн нэгжүүдийн хуулийн албаны ажилтны ёсоор цалин авдаг корпорациудын хуулийн зөвлөх өмгөөлөгчид нь хуульчийн бүхий л бүрэн эрхийг эдлэх бөгөөд нийт хуульчдын 10 гаруй хувийг эзэлдэг. Корпорацийн буюу хуулийн этгээдийн статустай цөөнгүй олон нийтийн байгууллагууд дээрх байдлаар өөрийн гэсэн хуульчтай байдаг³.

Холбооны гүйцэтгэх засаглалын болон тэдгээрийн харьяа байгууллагууд, захиргааны байгууллага, орон нутгийн өөрөө удирдах засаглалын байгууллага, хууль тогтоох байгууллагуудын хуулийн албадын орон тооны ажилтнууд, мөн түүнчлэн холбооны болон бусад прокурорын газрын дарга, албан хаагчид /*Attorney, Prosecutor*/, улсын төсвөөс үйл ажиллагааных нь төлбөр төлөгддөг “Олон нийтийн хамгаалал”-ын байгууллагуудын өмгөөлөгчид гэсэн төрийн байгууллагын хуульчид мөн л томоохон бүлгийг үүсгэнэ⁴.

Мөрдөх алба, цагдаагийн ажилтнууд нь хуульчийн дипломтой байх боловч АНУ-ын хууль зүйн үйл ажиллагааны стандартын дагуу хуульч гэж тооцогддоггүй. Харин тэдгээр байгууллагуудын хуулийн албаны ажилтнууд хуульч гэж тооцогддог. Нийтдээ төрийн албанд нийт хуульчдын өөрөөр хэлбэл өмгөөлөгчийн патент бүхий хуульчдын 15 хувь нь ажилладаг⁵.

Практик үйл ажиллагаа эрхэлдэг хуульчдийн бүлгийн дунд шүүгчид тусгай хэсгийг бүрдүүлнэ. Төрийн, өмгөөлөлийн, бизнесийн байгууллагуудын хуулийн албанд, прокурорын байгууллагуудад хууль зүйн практик туршлага эзэмшсэн хуульчид, мөн түүнчлэн эрх зүйн туршлага, нэр хүнд бүхий профессорууд дундаас шүүгчийн албан тушаалд томилдог. Холбооны шүүгч 1200 орчим байдаг бол

¹ Entering Class Profile, Yale Law School, <http://www.law.yale.edu/admissions/profile.htm>.

² Class Profile and Fact Sheet, Harvard Law School,

³ <http://www.law.harvard.edu/prospective/jd/apply/classprofile.html>.

⁴ Law School Facts, Stanford Law School, http://www.law.stanford.edu/school/facts/#degrees_and_admissions.

⁵ State Bar Announces Results for the February 2010 California Bar Exam, The State Bar of California, <http://www.calbar.ca.gov/AboutUs/News/201011.aspx>

муж, орон нутгийн шүүгчдийн тоо ойролцоогоор 30 мянга байдаг. Дээрх бүгдээс гадна цэргийн хууль зүйн тогтолцоонд 4000 орчим хуульч ажиллаж байна⁶.

Хуульчдын хоёр дахь ангилалд хууль зүйн практик болон шинжлэх ухаанаас холдсон бизнес, улс төрийн гэх мэт карьер хийж байгаа хуульчид хамаарах боловч тэднийг хуульчийн үйл ажиллагааны албан ёсны статистик, тодорхойлолтонд хамааруулдаггүй. Гэхдээ АНУ-д хуульчийн диплом эзэмшсэн хүмүүсийн нийгэм улс төрийн амьдралд үзүүлэх үүрэг өндөр бөгөөд тэдгээрийг илтгэх цөөн баримтыг авч үзье. АНУ-ын 44 ерөнхийлөгчийн 26 нь хуульч байсан, тэр дундаа А.Линкольн, Ф.Рузвельт, Г.Трумэн, Р.Никсон, Б.Клинтон болон өнөөгийн ерөнхийлөгч Барак Обама нар тус тус өмгөөлөгч байсан бол сенатчдын 2/3, төлөөлөгчдийн танхимын гишүүдийн бараг тал хувь нь хуульчид байдаг. Түүнчлэн муж улсуудын амбан захирагчдын тал нь, дипломатуудын 40 хувь нь хуульчийн дипломтой байдаг бол 60-аад оноос эхлэн засгийн газарт өндөр албан тушаал хашиж байгаа этгээдүүдийн 45 хувь нь хуульчид, харин төрийн аппаратад орсон хүмүүсийн 25 хувь нь өмгөөллийн ажлаас шилжин ирсэн байдаг аж⁷.

Хуульчдын гурав дахь ангилал нь эрдэм шинжилгээ, сурган хүмүүжүүлэх ажил эрхэлдэг судлаач, эрдэмтэн хуульчид юм. Албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн 181 сургалтын байгууллагад ажилладаг эрх зүйн багш нарын тоо 5395. Түүнээс гадна эрхзүйн хичээлийг заадаг 4000 хуульч байдаг.

Хууль зүйн сургуулийг төгссөн этгээд эрдэм шинжилгээний ажлыг сонгоогүй л бол өмгөөлөгч эсхүл шүүгчийн туслах, референтийн мөн түүнчлэн төрийн байгууллагуудын хуулийн албаны аппарат, прокурорын байгууллагуудад бага албан тушаал дээр очин ажлын гараагаа эхэлдэг⁸.

Тухайн хүнийг ердөө нэг чиглэлээр явуулна гэсэн чиг хандлага Америкийн хуульчдын мэргэжлийн бүлгийн дунд байдаггүй.

АНУ-ын хууль зүйн үйл ажиллагааны хувьд эргэлт, хөрвөж ажиллах хандлага их байдаг гэж үздэг. Хувийн өмгөөллийн үйл ажиллагаанаас төрийн албанд шилжих мөн төрийн албанаас хувийнх руу шилжих үзэгдэл түгээмэл байдаг. Төрийн албанд идэвхитэй, туршлагатай хуульч-эрдэмтдийг татан оролцуулах нь элбэг. Шүүгчдээр ихэвчлэн улс төрийн идэвхитэй, туршлагатай өмгөөлөгчдийг сонгодог. Тойргийн прокурорын (*County Attorney, County Prosecutor*) албаны албан тушаалыг хуульчид улс төр, өндөр албан тушаал руу үсрэх тавцан гэж хардаг гэсэн практик судалгаа байдаг ч олон яллагчид шүүгч болдог. Корпорацийн хуульчид өөрийн карьерыг бүхэлд нь бизнесийн үйл ажиллагаанд зориулах нь цөөнгүй⁹. Америкийн корпорациуд хуульчдаа удирдах албан тушаалд томилох нь улам бүр ихэссээр байгаа бөгөөд олон корпорациудад ерөнхий хуулийн зөвлөх нь албан тушаалаараа гүйцэтгэх дэд ерөнхийлөгчийн үүргийг гүйцэтгэдэг байна.

Корпорацид үйлчилгээ үзүүлдэг өмгөөлөгчид эсвэл корпорацид ажилладаг хуульчдийг засаг захиргааны зохицуулах байгууллагууд буюу төрийн албанд урьж ажиллуулах нь их бөгөөд тухайн төрийн байгууллагуудад тодорхой хугацаанд ажилласны дараа эдгээр хуульчид корпорациудын удирдах албан тушаалд эргэн ирдэг.

Хуульч мэргэжлийн дунд шүүгчийн ажил ялангуяа насаараа албан тушаалд томилогддог холбооны шүүгчийн ажил ихэд нэр хүндтэйд тооцогдох бол олон нийтийн үзэмжээр бол корпорацийн өмгөөлөгчид, эрдэмтэн хуульчид дараагийн байрт тавигдаж, засаг захиргааны байгууллагууд, төрийн байгууллагын хуулийн албаны ажилтнууд зэрэг хуульчид араас нь ордог. Өмгөөлөгч-улстөрчдийн бүлэг нь төр болон улс төрийн өндөр албан тушаалд хүрсэн тодорхой зүтгэлтнүүдийн улс төрийн үйл ажиллагааны амжилтаар нэр хүнд нь хэмжигдэж байдаг.

Хууль зүйн боловсрол: 2012 оны байдлаар АНУ-д 220 /хувийн болон улсын/ хууль зүйн дээд сургууль, хуулийн сургууль, их сургуулиудын бүрэлдэхүүнд багтдаг коллеж болон бие даан үйл ажиллагаа явуулдаг хуулийн сургууль коллеж үйл ажиллагаа явуулж байна. Хууль зүйн сургуулиудын 203 нь албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөнд тооцогддог. Хууль зүйн их дээд сургуулийг албан ёсоор хүлээн зөвшөөрөх асуудлыг шийддэг байгууллага нь Америкийн хуульчдын холбоо /*American Bar Association*/ байдаг.

Энэ байгууллага нь тухайн хууль зүйн их дээд сургуулийн зүгээс хангах ёстой шаардлагуудын жагсаалтыг баталдаг. Эдгээр шаардлагуудын заримаас дурьдвал мэргэшсэн сурган хүмүүжүүлэгчдийн

⁶ MBA officers welcome new attorneys as bar exam pass rates increase, Massachusetts Bar Association Lawyers Journal, <http://www.massbar.org/publications/lawyers-journal/2008/january/mba-officers-welcome-new-attorneys-as-bar-exam-pass-rates-increase>

⁷ Law Society of England and Wales. How to practise in USA (2007), <http://international.lawsociety.org.uk/ip/americas/610/practise>

⁸ Bureau of Labor Statistics, United States Department of Labor, <http://www.bls.gov/cps/>.

⁹ Boeing Co. (1980) 444 U.S. at 478, see also Sprague v. Ticonic Nat'l Bank (1939) 307 U.S. 161, 167 and Trustees v. Greenough (1882) 105 U.S. 527.

тодорхой багтай байх, сургалтанд тохирсон, тохилог байртай байх, тодорхой төсөвтэй байх, номын санд нь сургалтын, лавлагааны болон эрх зүйн бусад ном сурах бичиг тогтоосон тоо шалгуурын дагуу байх, сургалтын тодорхой хөтөлбөрүүд бүхий байх зэрэг шаардлагууд багтсан байдаг.

Албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн гэсэн жагсаалтанд багтаагүй хууль зүйн дээд сургуулиуд нь ихэвчлэн орон нутгийн оршин суугчдаас оюутнуудаа авсан эсвэл оройгоор боловсрол олгоход чиглэгдсэн хувийн хууль зүйн сургуулиуд байдаг. Албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн сургуулиудаас ялгаатай нь эдгээр сургуулиудын сургалтын чанар доогуур, харин олгож буй диплом нь төгсөгчид өд өрдөө зарим нэг мужид өмгөөлөгчийн үйл ажиллагаанд оролцох эрх авах боломж бүхий байдагт оршдог байна.

АНУ-ын боловсролын тогтолцоо нь өөрийн өвөрмөц онцлог бүхий бөгөөд дээд боловсрол нь хоёр шаттай байдаг. Дунд боловсрол зургаан наснаас эхлэж, сургалт 12 жил үргэлжилдэг. Дараа нь тухайн хүн коллежид ерөнхий дээд боловсрол олж авч болно. Коллежид 3-4 жил сурч төгссөнөөр төгсөгч “Bachelor of Arts”-ын диплом авна.

Мэргэжлийн дээд боловсролыг мэргэшсэн сургуулиуд эсвэл коллеж, их сургуулиар олж авах бөгөөд зөвхөн ерөнхий боловсролын коллеж төгссөний дараа эдгээр сургалтын байгууллагуудад элсэн орно. Тиймээс хууль зүйн их дээд сургууль, хуулийн коллежид орохын тулд ерөнхий боловсролын коллежийн дипломтой байх шаардлагатай.

Хууль зүйн их дээд сургуульд элсэн орохын тулд элсэлтийн шалгалт өгдөггүй, харин элсэгчид шуудангаар илгээх Law School Admissions Test (LSAT) буюу “Хууль зүйн сургуульд суралцах чадварын тест” нь шалгалтыг орлодог. Түүнчлэн элсэгчийн коллежид сурч байх үедээ авсан үнэлгээг тухайн сургуулийн захиргаа сургалтын албанаас харгалзаж үздэг. Хууль зүйн сургуульд элсэх уралдаант шалгалт маш өрсөлдөөнтэй болох бөгөөд 40 мянган хуваарь дээр 150-160 мянган хүн өрсөлддөг /2011-2012 оны албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн их дээд сургуулиудын мэдээлэл/, харин дээд зэрэглэлийн нэр хүндтэй сургуулиудын хувьд нэг хуваарь дээр 40 орчим хүн өрсөлддөг.

Өнгөрсөн 2011/2012 оны хичээлийн жилд албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн их дээд сургуулиудад 151800 оюутан суралцаж байжээ. Сургалтын хугацаа нь гурван жил. Нэгдүгээр дамжаанд заавал үзэх хичээлүүд орох бөгөөд эдгээрт гэрээ, өмчийн, эрүүгийн захиргааны эрх зүй, хуульчийн мэргэжил, эрх зүйн философи зэрэг хичээлүүд багтдаг. Сургалтын хоёр болон гурав дахь жилд заавал үзэх ёстой хичээл байхгүй ч оюутны судлах ёстой хичээлүүдийн доод хэмжээг буюу багц цагийг тогтоож өгдөг. Түүнчлэн долоо хоногт үзэж судлах ёстой сургалтын доод цагийг тогтооно.

Хууль зүйн сургуулиудын сургалтын арга нь өргөдөл гомдол, давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг задлан шинжлэх дээр чиглэгдсэн байдаг. Хууль зүйн боловсролд оюутанд эрх зүйн текстийг цээжлүүлэх биш харин оюутны задлан шинжлэх чадварыг хөгжүүлэх нь чухал байдаг.

Тиймээс лекц унших зэрэг арга бараг л байхгүй бөгөөд хичээлийн үеэр багш сурган хүмүүжүүлэгчид оюутнуудтай чөлөөтэй идэвхитэй харилцан ярилцдаг. /Сократын арга/. Энэ ч утгаараа семинарууд эрчимтэй явагддаг. Багш нар зохиомол болон практикийн бодит нөхцөлөөс үүдсэн хэргийг авч хэлэлцэх ажиллагааг зохион байгуулах бөгөөд энэ үеэр оюутнууд хэргийн оролцогчдын үүргийг тодорхойлж, нотлох баримт гарган, судалж, байцаан шийтгэх ажиллагааг мэдээлж, баримт дэлгэх зэрэг ажиллагаа явуулдаг. Нэгдүгээр дамжаа төгсөх үедээ оюутнууд шүүхийн үйл ажиллагааны үзүүлэх тоглолт хийх байдлаар мэдлэг, урч чадвараа үзүүлж тайлагнадаг байна.

Ирээдүйн хуульчдын сургалтын хөтөлбөрт практик хичээл ихээр орохын дээр сургалтын үед бие даасан судалгааны ажлын дадлыг төлөвшүүлэхэд ихээхэн анхаарал хандуулдаг. Америкийн томоохон хууль зүйн дээд сургуулиуд Law review буюу “Эрх зүйн тойм” зэрэг хууль зүйн сэтгүүлүүдийг оюутнуудаараа гаргуулах нь түгээмэл. Эдгээр сэтгүүлүүдийн редакцийн зөвлөлд хичээлдээ онцгой амжилттай суралцаж байгаа оюутнууд багтдаг. Оюутнууд өөрсдөө профессор болон алдартай хуульчдийн нийтлүүлэх нийтлэлүүдийг хүлээн авч сонголтыг хийнэ.

Оюутнуудын мэдлэгийг бичгээр авсан шалгалтын үндсэн дээр үнэлнэ. Шалгалтын ажлыг А, В, С, D гэсэн үсгэн үнэлгээгээр болон “тэнцсэн/тэнцээгүй” гэсэн системээр дүгнэнэ. Оюутнуудын үнэлгээг багш нар гуравдагч этгээдэд задлахыг хориглодог.

Сургалт дууссаны дараа дипломын ажил бичиж хамгаалах бөгөөд төгсөгч диплом, “Juris Doctor”-ын зэрэг авах бөгөөд энэ нь хуульчийн мэргэжил, эрдмийн дээд зэрэг цолыг илэрхийлсэн ойлголт биш бөгөөд хууль зүйн практик эрхлэхэд шаардлагатай, хангалттай мэдлэг эзэмшсэн болохыг нотолдог байна. Өрөөр хэлбэл манай улсын эрх зүйн боловсролын тогтолцоон дахь бакалаврын зэрэгтэй адилтган ойлгогдож болохуйц боловсролын зэрэг юм.

Эрдэм шинжилгээ, сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаанд өөрийгөө зориулахыг хүссэн хүмүүс Master of Laws буюу “Эрх зүйн магистр” /гүнзгийрүүлсэн хөтөлбөрөөр жил хичээллэж зохих диссертацийг танилцуулна/ эсвэл илүү дээд зэрэглэл болох Doctor of Laws “Хууль зүйн ухааны доктор” /2 жил суралцаж, зохих диссертаци хамгаална/-ын сургалтанд үргэлжлүүлэн суралцаж болно.

АНУ-д жилд дунджаар 1700-2000 хуульч “Эрх зүйн магистр”-ын зэрэг авсан бол 40-60 хуульч хууль зүйн ухааны докторын зэрэг хамгаалдаг байна.